

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 03 сарын 25-ны  
өдрийн 6187 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 15 өдөр


Дугаар 84


Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын  
журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- 1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.
- 2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН





**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын  
журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон түүний холбогдох ажилтанд зориулсан мөнгөн зээлийн үйл ажиллагааны харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон бусад дүрэм, журмын талаарх сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

### **Хоёр.Сургалтын зохион байгуулалт**

2.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагааны харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон бусад дүрэм, журмын талаарх сургалтыг цахимаар зохион байгуулна.

2.2.Сургалт зохион байгуулагч нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-той сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

2.3.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер, байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь энэ журмын 2.2-т заасан эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

2.4.Энэ журмын 2.3-д заасан этгээд сургалтын системд байршуулсан хичээлийг хэдийд ч хандаж судлах, шалгалт сорилго /тест/ өгөх боломжтой байх ба сургалтын үргэлжлэх хугацаа 72 цагаас илүүгүй байна.

### **Гурав.Сургалт зохион байгуулагчид тавигдах шаардлага**

3.1.Сургалт зохион байгуулагч дараах шаардлага хангасан байна:

3.1.1.сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий сургагч багштай байх;

3.1.2.сургалт зохион байгуулах цахим систем, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;

3.1.3.сургалтын үйл ажиллагааны журамтай байх;

3.1.4.батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж, эсхүл сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх;

3.1.5.сургалт зохион байгуулах цахим систем нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэлийн байгууллагаас сургалтад тэнцсэн оролцогчийн мэдээллийг шалгах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байх.

3.2.Сургалтын төлбөрийг сургалт зохион байгуулагчийн Хороотой байгуулах сургалтын гэрээгээр тодорхойлно.

3.3.Сургалт зохион байгуулагч нь сургалтын хөтөлбөрийн төслийг Хороонд хүргүүлж, батлуулна.

3.4.Сургалт зохион байгуулагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан этгээдэд 1 жилийн дотор үнэ төлбөргүйгээр сургалтыг зохион байгуулна.

